

ЭДИЙН ЗАСАГ БОЛОН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХАРИЛЦААНААС ҮҮССЭН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН МАРГААНЫГ АРБИТРААР ШИЙДВЭРЛҮҮЛЭХ ТУХАЙ КОНВЕНЦИ

/Москва хот, 1972 он/

Бүгд Найрамдах Болгар Ард Улс, Бүгд Найрамдах Унгар Ард Улс, Бүгд Найрамдах Ардчилсан Герман Ард Улс, Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Бүгд Найрамдах Польш Ард Улс, Бүгд Найрамдах Социалист Румын Ард Улс, Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс, Бүгд Найрамдах Социалист Чехословак Улсын Засгийн газрууд нь:

Эдийн засаг болон шинжлэх ухааны, техникийн хамтын ажиллагааг цаашид гүнзгийрүүлж, боловсронгуй болгох зорилгоор эрх зүйн таатай хангах тэмүүллийг удирдлага болгон,

Энэхүү хамтын ажиллагааг хэрэгжүүлэх явцад үүсэх маргаантай асуудлуудыг зохих ёсоор шийдвэрлэх нь түүнийг амжилттай хөгжүүлэхэд нөлөөлнө гэсэн байр сууринаас хандаж,

Эдгээр орнуудын арбитрын шүүх нь гадаад худалдааны үйл ажиллагаатай холбоотой маргааныг хянан шийдвэрлэх үр дүнтэй арга болохыг амьдралд харуулсныг харгалзан

Эдийн засаг болон шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны бүх төрлийн харилцаанаас үүссэн маргааныг шийдвэрлэхэд арбитрын аргыг илүү өргөн хэрэглэх зорилгоор

дараах зүйлүүдийг харилцан тохиролсон байна:

1 дүгээр зүйл.

1. Энэхүү Конвенцид нэгдэн орсон орнуудын эдийн засаг болон шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны явцад аж ахуйн нэгж байгууллагуудын хооронд гэрээний болон бусад иргэний эрх зүйн харилцаанаас үүсэн гарах шүүхийн харьяалалд хуулиар хамруулснаас бусад бүх маргааныг арбитраар шийдвэрлүүлнэ.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан харилцаанд бараа худалдах, худалдан авах, үйлдвэрлэлийг хоршоолох тухай гэрээний харилцаа, мөн ажил гүйцэтгэх, барилга, угсралт, төсөл, хайгуул, шинжилгээ судалгаа, төсөл зохион бүтээх, туршилт явуулах, тээвэр экспедицийн болон бусад үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой харилцаа болон энэхүү Конвенцид нэгдэн орсон орнуудын эдийн засаг шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны явцад үүссэн бусад иргэний эрх зүйн харилцааг хамруулан авч ойлгоно.

3. Энэхүү конвенцийн дагуу аж ахуйн нэгж байгууллага гэдэгт энхүү конвенцид нэгдэн орсон аль нэг улсад оршин байдаг иргэний эрх зүйн субъект болох үйлдвэрийн газар, трест, нэгдэл, комбинат, аж ахуйн тооцоон дээр ажиллаж буй төв удирдах газар, түүнчлэн шинжлэх ухаан эрдэм шинжилгээний институт, төсөл зохион бүтээх товчоо зэрэг бсад ижил төстэй байгууллагуудыг хамруулан авч ойлгоно.

2 дугаар зүйл.

1. Энэхүү конвенцийн 1 дүгээр зүйлд заасан маргааныг хариуцагчийн улсын Худалдаа аж үйлдвэрийн танхимын дэргэдэх арбитраар эсвэл талуудын тохиролцсоны дагуу энэхүү конвенцид нэгдэн орсон гуравдагч орны арбитраар шийдвэрлүүлнэ.
2. Энэхүү конвенцид нэгдэн орсон улсуудад зарим нэг төрлийн маргааныг тусгай дагнасан арбитраар шийдвэрлүүлэхээр заасан бол тухайн маргааныг талуудын харилцан тохиролцсоны дагуу энэ дагнасан арбитраар шийдвэрлүүлнэ.
3. Үндсэн нэхэмжлэл үүссэн эрх зүйн харилцаанаас үүссэн сөрөг нэхэмжлэл болон шаардлагыг тооцох тухай хүсэлтийг үндсэн нэхэмжлэлийг шийдвэрлэж байгаа арбитраар шийдвэрлүүлнэ.

3 дугаар зүйл.

1. Гэрээ байгуулахыг тулган шаардах эсвэл гэрээний аль нэг нөхцлийг тулган хүлээлгэх тухай хүсэлтийг арбитра хүлээн авахгүй.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэг нь гэрээний үүргээ зөрчсөний төлөө торгууль төлөх эсвэл гэрээний үүргээ зөрчсөний улмаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх тухай хохирсон талын хүсэлтийг эрх бүхий арбитра авч хэлэлцэхэд хамаарахгүй.

4 дүгээр зүйл.

1. Энэхүү конвенцийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан арбитраын шийдвэр эцсийн бөгөөдзаавал биелэгдэх хүчин чадалтай байна. Арбитраын шийдвэрийг талууд сайн дураараа биелүүлэх үүрэгтэй.
2. Энэ арбитраын шийдвэр нь цаашаа ямар нэг шат дамжихгүй бөгөөд энэхүү конвенцид нэгдэн орсон улсуудад тухайн орны шүүхийн шийдвэр ямар журмаар биелэгддэг тэр журмаар биелэгдэнэ.
3. Энэ зүйлийн 1 ба 2 дахь хэсэг нь эвлэрлийн гэрээг баталгаажуулсан арбитраын шийдвэрт мөн адил хэрэглэгдэнэ.
4. Хэрэв арбитра оршин байгаа улсын хуулиар өөрөөр зохицуулагдаагүй бол энэ зүйлийн 1 ба 2 дахь хэсэг нь энэхүү конвенцийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан дагнасан арбитраын шийдвэр мөн дагнасан арбитраын эвлэрлийн гэрээг баталгаажуулсан арбитраын шийдвэрт мөн адил хамаарна.

5. Энэхүү конвенцийн 2 дугаар зүйлд заасан арбитрын шийдвэр болон арбитрын шийдвэрээр баталгаажсан эвлэрлийн гэрээг талууд сайн дураар биелүүлээгүй тохиолдолд 2 жилийн хугацаанд албадан биелүүлэх арга хэмжээ авч болно. Энэ хөөн хэлэлцэх хугацааг албадан биелүүлэх арга хэмжээ авхуулах тухай хүсэлт гаргасан тал арбитрын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс, харин арбитрын шийдвэрийг шуудангаар явуулсан тохиолдолд баталгаат шууданг хүлээн авсан тухай шуудангийн байгууллагын тамга тэмдгийн өдрөөс эхлэн тооцно. Эвлэрлийн гэрээ байгуулсан тохиолдолд энэ хугацааг тэрхүү эвлэрлийн гэрээг байгуулсан өдрөөс эхлэн тооцно.

5 дугаар зүйл.

1. Арбитрын шийдвэрийг биелүүлж байгаа улсын шүүхийн шийдвэр биелүүлэх газар нь арбитрын шийдвэрийг баталгаажуулж биелүүлэхээс зөвхөн дараах тохиолдолд татгалзаж болно:
 - а/ хэрвээ арбитрын шийдвэр нь энэхүү конвенциор тогтоосон харьяалалын журмыг зөрчиж гарсан
 - б/ хэрвээ арбитрын шийдвэрээр хариуцлага хүлээсэн тал нь арбитрын ажиллагааны журмыг зөрчсөн эсвэл өөрөө урьдчилсан сэргийлэх, арбитрын бүрэлдэхүүнд мэдэгдэх боломжгүй байсан өөр ямар нэг нөхцөл байдлын улмаас өөрийн эрхийг хамгаалах боломжгүй байсан гэдгийг нотлосон
 - в/ хэрвээ арбитрын шийдвэрээр хариуцлага хүлээсэн тал нь арбитрын шийдвэр гарсан улсын үндэсний хууль тогтоомжоор тухайн арбитрын шийдвэрийг хүчингүй болгосон, түдгэлзүүлсэн гэдгийг нотлосон
2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн “а”, “б”-д заасан үндэслэлээр арбитрын шийдвэрийг баталгаажуулж гүйцэтгэхээс татгалзсан тохиолдолд уг хүсэлтийг гаргасан тал арбитрын шийдвэрийг баталгаажуулж гүйцэтгэхээс татгалзсан тухай шүүхийн тогтоол гарсан өдрөөс хойш 3 сарын хугацаандэрх бүхий байгууллагад тэр үндэслэлээр нь шинэ нэхэмжлэл гаргах эрхтэй.

6 дугаар зүйл.

1. Энэхүү конвенциэр зохицуулагдаж байгаа асуудлаар нэгдэн орсон улсуудын хооронд аль нэг төрлийн иргэний эрх зүйн маргааныг аль нэг байгууллагын онцгой харьяалалд хамруулснаас бусад урд өмнө байгуулсан хоёр болон олон талт гэрээг хэрэглэхгүй.
2. Энэхүү конвенцид гарын үсэг зурах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан үндэстний хууль тогтоомжоор аль нэг төрлийн иргэний эрх зүйн маргаан шүүх болон бусад төрийн байгууллагын онцгой харьяалалд хамруулсан бол тэдгээр маргаанд энэхүү конвенцийг хэрэглэхгүй.

7 дугаар зүйл.

1. Энэхүү конвенци хүчин төгөлдөр үйлчилж эхлэх өдөр ажиллагаа хийгдэж байгаа хэргийг энэхүү конвенцийг хөндөхгүй.

8 дугаар зүйл.

1. Энэхүү гэрээнд гарын үсэг зурсан орнууд конвенцийг соёрхон батлана. Соёрхон батласан тухай гэрчилгээг Эдийн засгийн харилцан туслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын газарт хадгалуулна.
2. Энэхүү конвенци нь Эдийн засгийн харилцан туслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын газарт тавдахь соёрхон батласан тухай гэрчилгээг өгсөн өдрөөс хойш 90 дэх хоног дээр хүчин төгөлдөр болно.
3. Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болсноос хойш Эдийн засгийн харилцан туслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын газарт соёрхон батласан тухайн гэрчилгээг өгсөн орнуудын хувьд соёрхон батласан тухай гэрчилгээг хадгуулахаар өгсөн өдрөөс хойш 90 хоногийн дараа энэхүү конвенци хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

9 дүгээр зүйл

1. Энэхүү конвенцийг хүчин төгөлдөр болсноос хойш конвенцид нэгдсэн орсон орнуудын зөвшөөрлөөр бусад орнууд нэгдэн орох тухай бичиг баримтыг Эдийн засгийн харилцан туслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын газарт өгөх замаар энэ конвенцид нэгдэн орж болно.
2. Энэхүү конвенцид нэгдэн орсон улс энэ конвенцийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан ямар арбитр 1 дүгээр зүйлд заасан маргааныг шийдвэрлэх болохыг Эдийн засгийн харилцан туслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэнэ.

10 дугаар зүйл.

1. Энэхүү конвенцид нэгдэн орсон улс болгон Эдийн засгийн харилцан туслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдсэнээр энэ конвенциос гарч болно. Конвенциос гарах тухай мэдэгдэл түүнийг Эдийн засгийн харилцан туслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын газар хүлээж авснаас хойш 12 сарын дараа хүчин төгөлдөр болно. Конвенциос гарах тухай мэдэгдэл хүчин төгөлдөр болох өдөр арбитрын ажиллагаа хийгдэж байгаа хэрэгт конвенциос гарах асуудал нөлөөлөхгүй.

11 дүгээр зүйл.

1. Эдийн засгийн харилцан туслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын газар энэхүү конвенцид гарын үсэг зурсан болон нэгдэн орсон улсуудын талаарх мэдээлэл, соёрхон батласан болон нэгдэн орох

тухай бичиг баримтыг хадгалуулахаар өгсөн өдрийн талаарх мэдээлэлийг нэн даруй мэдэгдэнэ.

12 дугаар зүйл.

1. Эдийн засгийн харилцан туслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын газар нь энэхүү конвенцийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын нарийн бичгийн дарга нарын газарт түүний дүрмийн дагуу бүртгүүлэх талаар шаардлагатай арга хэмжээг авна.

13 дугаар зүйл.

1. Энэхүү конвенцийг Эдийн засгийн харилцан туслах зөвлөлийн нарийн бичгийн дарга нарын газарт хадгалуулахаар өгөх ба уг газар нь энэ конвенцийн зохих ёсоор баталгаажсан хуулбарыг конвенцид гарын үсэг зурсан болон түүнд нэгдэн орсон улсуудад илгээнэ.

Энэхүү конвенцийг 1972 оны 5 дугаар сарын 26-ны өдөр Москва хотноо орос хэл дээр нэг хувь үйлдсэн болно.